

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДААТГАЛЫН ГАЗАР

ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН 2009 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

ТАНИЛЦСАН:

ХОРООНЫ ДАРГА
ХОРООНЫ ГИШҮҮН
ХОРООНЫ ГИШҮҮН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Д. БАЯРСАЙХАН
Б. ШАРАВСАМБУУ
Д. ДҮГЭРЖАВ
О. ГАНБАТ

ХЯНАСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
ДААТГАЛЫН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА

С. ГАНБОЛД
П. ЦЭРЭНДЭЖИД

БОЛОВСРУУЛСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Б. ОЮУНТУЯА

УЛААНБААТАР ХОТ
2009 ОН

2009 оны 2 дугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 75.8 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 8.6 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 8.4 хувийг дансны авлага, үлдэх 7.1 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 15.3 пунктээр, дансны авлага 1.8 пунктээр өсч, богино хугацаат хөрөнгө оруулалт 12.2 пунктээр, бусад эргэлтийн хөрөнгө 5.0 пунктээр тус тус буурсан байна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нийт эргэлтийн хөрөнгөнд эзлэх хувь хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс нилээд хэдэн пунктээр өссөн гол шалтгаан нь өнгөрөгч 2008 оны 3 дугаар улирлаас эхлэн Хорооны 2006 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага” журмын дагуу даатгалын компаниудын санхүүгийн байдлыг шалгаж эхэлсэнтэй холбоотой байна (Хүснэгт-2).

Хүснэгт-2

Эргэлтийн хөрөнгө

(сая төг)

Үзүүлэлтүүд	2008-II		2009-II		өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	18 459.9	60.5	25 488.3	75.8	7 028.4	138.1
Богино хугацаат хөрөнгө оруулалт	6 331.1	20.8	2 899.5	8.6	-3 431.6	45.8
Дансны авлага	2 007.4	6.6	2 839.1	8.4	831.7	141.4
Бусад эргэлтийн хөрөнгө	3 698.8	12.1	2 380.3	7.1	-1 318.5	64.3
Эргэлтийн хөрөнгийн дүн	30 497.2	100.0	33 607.2	100.0	3 110.0	110.2

Энэ оны 6 дугаар сарын 30-ны байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 13.4 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр нийт даатгалын зах зээл дээрх хөрөнгийн 35,3 хувийг эзэлж байгаа бол “Болор-Итгэл даатгал” ХХК хамгийн бага буюу 0.5 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр зах зээлийн нийт хөрөнгийн 1.4 хувийг эзэлж байна (Хүснэгт-3).

Даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 51,1 хувийг ердөө 3 даатгалын компани (“Монгол даатгал”, “Бодь даатгал”, “МИГ даатгал” ХХК) –ийн хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт-3

Нийт хөрөнгийн хэмжээ


№	Компанийн нэр	Нийт хөрөнгө (сая төг)	Эзлэх хувь
1	Монгол даатгал	13 435.9	35.3
2	Бодь даатгал	3 205.9	8.4
3	Миг даатгал	2 803.1	7.4
4	Прайм женерал даатгал	2 714.0	7.1
5	Номин даатгал	2 123.2	5.6
6	Ард даатгал	2 022.7	5.3
7	Түшиг даатгал	1 670.4	4.4

8	Практикал даатгал	1 533.9	4.0
9	Улаанбаатар хотын даатгал	1 317.1	3.5
10	УБ даатгал	1 216.1	3.2
11	Монгол траст Холдинг даатгал	1 177.9	3.1
12	Нэйшнл лайф даатгал*	1 090.6	2.9
13	Мөнх даатгал	912.0	2.4
14	Ган зам даатгал	910.5	2.4
15	Жонон даатгал	725.9	1.9
16	Нийслэл даатгал	641.7	1.7
17	Болор-Итгэл даатгал**	524.8	1.4
	ДҮН	38 025.7	100.0

II. ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

2009 оны 2 дугаар улиралд нөөц сангийн хэмжээ 19.5 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 3,1 тэрбум төгрөгөөр буюу 13.7 хувиар буурсан мэт харагдаж байгаа боловч нөөц сангийн бодит бууралт биш бөгөөд зарим компаниуд Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 241 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагын мэдээллийн нэгдсэн сангийн журам”-ын хавсралтын дагуу орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн санг балансын нөөцийн сангийн хэсгээс хасч, өр төлбөр хэсэг дэх урьдчилж орсон орлогоор бүртгэх болсонтой холбоотой байна (Зураг-2).

Зураг-2



Тайлант хугацаанд даатгалын салбарын хэмжээгээр 424.9 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан бол өнгөрсөн онд 372.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан байна.

III. ОРЛОГО, ЗАРДАЛ

Тайлант хугацаанд даатгалын салбар 11.5 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсноос 2.6 тэрбум төгрөг буюу 22.6 хувийг давхар даатгалын хураамжид, 0.07 тэрбум төгрөг буюу 2.7 хувийг буцаасан даатгалын хураамжид олгож 8.8 тэрбум төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлого олжээ.

Энэ оны эхний хагас жилд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын нийт хураамжийн орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20.1 хувиар буюу 2,9 тэрбум төгрөгөөр буурахад “Жонон даатгал” ХХК-ийн орлого 93.4 хувиар, “Практикал даатгал” ХХК-ийн орлого 91.9 хувиар, “Монгол даатгал” ХХК-ийн орлого 13.6 хувиар, “Монгол траст холдинг даатгал” ХХК-ийн орлого 90.5 хувиар, “Мөнх даатгал” ХХК-ийн орлого 84.1 хувиар, “Нийслэл даатгал” ХХК-ийн 53.6 хувиар, “Түшиг даатгал” ХХК-ийн орлого 10.3 хувиар, “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн орлого 8.7 хувиар тус тус буурсан байдал нөлөөлжээ. Нийт хураамжийн орлогын бууралт нь улс орны эдийн засгийн ерөнхий байдал, иргэд, ААНБ-ын орлого буурснаас даатгалын гэрээ байгуулах, гэрээг сунгах тоо хэмжээ цөөрсөнтэй холбоотой.

Орлогод тооцсон хураамжийн 16,5 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан бүрдүүлэхэд, 24.7 хувийг нөхөн төлбөр олгоход зориулсан байна.

2008 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар даатгалын салбар 370.0 сая төгрөгийн ашиг (татвар төлөхийн өмнөх)-тай ажиллаж байсан бол энэ оны эхний хагас жилийн байдлаар 2.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээс 5.5 дахин өссөн байна. Татвар төлөхийн өмнөх ашгийн хэмжээ ийнхүү огцом өсөх болсон гол шалтгаан нь “Жонон даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Прайм генерал даатгал” ХХК, “Ган зам даатгал” ХХК, “Улаанбаатар хотын даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК-иудын ашиг 32.7 хувиас 3.8 дахин өссөн, өмнөх оны мөн үед алдагдалтай ажиллаж байсан “Монгол даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Мөнх даатгал” ХХК-иудын ашиг өссөнтэй холбоотой байна.

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа 17 даатгалын компанийг 2009 оны 2 дугаар улиралд олсон даатгалын хураамжийн орлогоор нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 3.8 тэрбум төгрөг буюу нийт зах зээлийн 33.4 хувийг эзэлж хамгийн өндөр орлого олсон бол “Болор-Итгэл даатгал” ХХК хураамжийн орлогогүй байна (Хүснэгт-4). Даатгалын зах зээл дэх нийт хураамжийн орлогын 66.7 хувийг “Монгол даатгал” ХХК, “МИГ даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК-иудын олсон хураамжийн орлого бүрдүүлж байна.

Хүснэгт-4

Даатгалын хураамжийн орлого

№	Компанийн нэр	Хураамжийн орлого (сая.төг)	Эзлэх хувь
1	Монгол даатгал	3 843.4	33.4


2	Миг даатгал	2 715.1	23.6
3	Бодь даатгал	1 115.2	9.7
4	Прайм женерал даатгал	1 003.6	8.7
5	Номин даатгал	881.6	7.7
6	Ард даатгал	603.9	5.2
7	Түшиг даатгал	499.0	4.3
8	Улаанбаатар хотын даатгал	304.0	2.6
9	Практикал даатгал	158.5	1.4
10	УБ даатгал	146.8	1.3
11	Мөнх даатгал	104.6	0.9
12	Ган зам даатгал	55.4	0.5
13	Нийслэл даатгал	42.0	0.4
14	Нэйшнл лайф даатгал*	15.2	0.1
15	Жонон даатгал	15.0	0.1
16	Монгол траст Холдинг даатгал	4.5	0.0
17	Болор-Итгэл даатгал**		0.0
	ДҮН	11 507.9	100.0

IV. ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ОЛГОВОР

Даатгалын салбарын хэмжээгээр 2009 оны 2 дугаар улиралд нийт 11.3 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсны 99.9 хувь буюу 11.3 тэрбум төгрөг нь ердийн даатгалын, 0.1 хувь буюу 7.2 сая төгрөг нь урт хугацааны даатгалын хураамжаас олсон байна. 2009 оны 2 дугаар улирлаас ердийн даатгалын хэлбэрийг олон улсад хэрэглэгддэг хэлбэрт нийцүүлэн шинэ хэлбэрээр гаргах болсон. Энэ оны эхний хагас жилд “авто тээврийн хэрэгслийн” даатгалын хураамжийн орлого хамгийн их буюу 3.1 тэрбум төгрөг, “хөрөнгийн” даатгалын хураамж 2.6 тэрбум төгрөг болж тэргүүлсэн бол “газар тариалангийн” даатгалаар хамгийн бага буюу 1.3 сая төгрөгийн орлого олсон байна (Зураг-3).

Зураг-3


**Даатгалын хураамжийн орлого,
2009 оны 2 дугаар улирлын байдлаар, сая төгрөгөөр**



Монгол улсын даатгалын зах зээлд урт хугацааны даатгалын компани 2008 оны 2 дугаар сард үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд энэ оны эхний хагас жилийн байдлаар 7.3 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажилласны 7.2 сая нь “хугацаат амьдралын” даатгал, 0.1 сая төгрөг нь “хуримтлалын” даатгал хийснээр олсон байна (Зураг-4).

Зураг-4


**Даатгалын хураамжийн орлого,
2009 оны 2 дугаар улирлын байдлаар, сая төгрөгөөр**



2009 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 2.6 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон бол урт хугацааны даатгалаар нөхөн төлбөр олгогдоогүй байна. Даатгалын нөхөн төлбөр олгосон байдлыг ердийн даатгалын шинэ хэлбэрээр авч үзэхэд “авто тээврийн хэрэгслийн” даатгалаар хамгийн өндөр буюу 1.3 тэрбум төгрөг буюу нийт нөхөн олговрын 48.8 хувь байсан бол “мал амьтдын” даатгалаар 2.0 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна (Зураг-5).

Зураг-5

**Даатгалын нөхөн төлбөр,
2009 оны 2 дугаар улирлын байдлаар, сая төгрөгөөр**



Энэ оны 2 дугаар улирлын байдлаар олгосон нөхөн олговрын хэмжээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад нийт нөхөн олговрын хэмжээ 8.3 хувиар буюу 0.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

V. НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

Тайлант хугацаанд даатгалын хохирол нөхөлтийн түвшин даатгалын салбарын дүнгээр 30.6 хувь болж 2008 оны мөн үеэс 6.9 пунктээр буурсан байна (Зураг-6).

Зураг-6



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирол нөхөлтийн түвшингээр харьцуулахад 2009 оны 2 дугаар улирлын байдлаар “Номин даатгал” ХХК хамгийн өндөр буюу 57.2 хувьтай байсан бол “Жонон даатгал” ХХК 0,0 хувьтай байсан байна (Хүснэгт-5).

Хүснэгт - 5

Даатгалын хохирол нөхөлтийн түвшин

№	Даатгалын компаниудын нэрс	Хохирол нөхөлтийн түвшин, хувиар		Өсөлт/бууралт, пунктээр
		2008-II	2009-II	
1	Номин даатгал	103.5	57.2	-46.3
2	Ард даатгал	42.9	39.9	-3.0
3	Мөнх даатгал	141.3	38.9	-102.4
4	Түшиг даатгал	29.5	36.9	7.4
5	Миг даатгал	16.8	29.1	12.3
6	Монгол даатгал	36.7	29.0	-7.7
7	Бодь даатгал	24.5	28.8	4.3
8	Прайм женерал даатгал	16.4	27.5	11.1
9	Улаанбаатар хотын даатгал	27.0	24.3	-2.7
10	УБ даатгал	16.7	19.3	2.6
11	Нийслэл даатгал	94.9	16.5	-78.4
12	Практикал даатгал	28.7	9.4	-19.3
13	Монгол траст Холдинг даатгал	17.8	3.6	-14.2
14	Ган зам даатгал	17.8	2.7	-15.1
15	Жонон даатгал	8.1	0.0	8.1
	ДҮН	37.5	30.6	-6.9

Даатгалын компаниудын 2009 оны 2 дугаар улиралд олгосон хохирол нөхөлтийн түвшинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад энэхүү үзүүлэлт нь “Номин даатгал” ХХК 46.3 хувь, “Мөнх даатгал” ХХК 102.4 хувиар, “Нийслэл даатгал” ХХК зэрэг компаниудын хувьд нилээд өндөр хэмжээгээр буурснаар нийт системийн хэмжээний хохирол нөхөлтийн түвшин 6.9 хувиар буурсан байна.

VI. ДАВХАР ДААТГАЛ

2008 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй 7 компани даатгалын эрсдэлээ давхар даатгуулж 2 614.9 сая төгрөгийн хураамж төлсөн нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 1,0 тэрбум төгрөгөөр буюу 28.6 хувиар, энэ оны эхний байдалтай харьцуулахад 2.1 тэрбум төгрөгөөр буюу 44.7 хувиар буурсан байна (Хүснэгт-6).

Хүснэгт-6

Давхар даатгалын хураамж

(сая төг)

№	Компанийн нэр	2008-II		2009-II		Өсөлт/бууралт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Ард даатгал	11.7	0.3	110.9	4.2	99.2	9.5 дахин
2	Бодь даатгал	2 696.9	73.6	353.8	13.5	-2 343.1	-7.6 дахин
3	Прайм женерал даатгал	89.9	2.5	271.5	10.4	181.6	3.0 дахин
4	Практикал даатгал	9.1	0.2		-		
5	Миг даатгал	369.4	10.1	1 541.4	58.9	1 172.0	4.2 дахин
6	Монгол даатгал	464.7	12.7	282.6	10.8	-182.1	60.8
7	Номин даатгал	21.4	0.6	49.9	1.9	25.8	2.3 дахин
8	Нэйшнл лайф даатгал			4.8	0.2		
	ДҮН	3 663.1	100.0	2 614.9	100.0	- 1 048.2	71.4

Өнгөрсөн оны мөн үед нийт давхар даатгалын хураамжид 73.6 хувийг эзэлж байсан “Бодь даатгал” ХХК-ийн давхар даатгалын хураамж 7.6 дахин буурсан нь МИАТ ХХК-ийн иргэний агаарын хөлгийн даатгалыг 2009 оноос хийхгүй болж харин энэхүү даатгалыг “Миг даатгал” ХХК хийх болсноор “Миг даатгал” ХХК-ийн давхар даатгалын хураамж нь 4,2 дахин өссөн байна. Харин дээрх бууралт нь өсөлтөөсөө 1.7 дахин илүү байгаа учраас давхар даатгалын нийт хураамж 28.6 хувиар буурсан байна.

VII. ДҮГНЭЛТ

2008 оны дунд үеэс Дэлхийн эдийн засаг тэр дундаа санхүүгийн сектор хүндрэлд орж энэ нь Монголын эдийн засагт 2008 оны сүүлч 2009 оны эхэн үеэс мэдрэгдэж эхэлсэн нь даатгалын секторт ч мөн адил ажиглагдаж байна. Тухайлбал энэ оны эхний хагас жилийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын хөрөнгийн нийт хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад бага (8.9%) хэмжээгээр өсч, тайлант хугацааны даатгалын нийт хураамжийн орлого 20.1 хувиар буурсан байдлаас харж болохоор байна.

Даатгалын салбарын татвар төлөхийн өмнөх нийт ашгийн хэмжээ 2008 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар 370.0 сая төгрөгийн ашиг (татвар төлөхийн өмнөх)-тай ажиллаж байсан бол энэ оны эхний хагас жилийн байдлаар 2.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээс 5.5 дахин өссөн байна. Энэ нь даатгалын салбарын үйл ажиллагаа маш их эрчимжиж өндөр ашигтай ажиллаж эхэлсэн мэт харагдаж байгаа боловч даатгалын нөөцийн санг байгуулах наймтын системээр тооцсон “өмнөх оны орлогод тооцоогүй хураамж”-ийн хэмжээ өндөр байгаатай холбоотойг хэлэх хэрэгтэй.

Дэлхийн даатгалын зах зээлтэй холбогддогийнхоо хувьд “давхар даатгалын хураамж”-ийн бууралт нь Дэлхийн эдийн засгийн хямрал Монгол Улсын даатгалын зах зээлд хэрхэн нөлөөлж байгааг тод харуулж байна. Тухайлбал энэ оны эхний хагас жилийн давхар даатгалын хураамжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.6 хувиар буюу 1.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.